



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/182

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн болон Монголын ус цаг уурчдын өдрийг тохиолдуулан Ус цаг уурын албыг хөгжүүлэх, гадаргын усны шинжилгээ хийх, агаарын бохирдлыг тодорхойлох, ард иргэдэд цаг агаарын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх чиглэлд идэвхи зүтгэл гарган хамт олноо манлайлан ажиллаж буй сан таны хөдөлмөр зүтгэлийг үнэлж Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Ховд өртөөний дарга, Ж.Жаргалзаяа, Холбоо сүлжээний технологич инженер Э.Ганцэцэг нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Ж.Жаргалзаяа, Э.Ганцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга, /А.Энхзаяа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

